


“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн
02 тоот тогтоогын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН
“АРИЛЖААНЫ ЖУРАМ”

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

Гарчиг

| | |
|---|-----------|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ | 4 |
| 1 дүгээр зүйл. Журмын зорилт. | 4 |
| 2 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тайлбар..... | 4 |
| 3 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ..... | 4 |
| 4 дугаар зүйл. Электрон арилжааны систем..... | 4 |
| 5 дүгээр зүйл. МХБ-ийн арилжааны үе шат. | 5 |
| 6 дугаар зүйл. Арилжааны өмнөх үе (Pre-Trading)..... | 5 |
| 7 дугаар зүйл. Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах (Opening Auction Call): | 5 |
| 8 дугаар зүйл. Энгийн арилжаа (Regular Trading)..... | 5 |
| 9 дүгээр зүйл. Ханшийн хэт өөрчлөлт..... | 5 |
| 10 дугаар зүйл. Арилжааны хаалтын үе (Market Close) | 5 |
| 11 дүгээр зүйл. Хаалтын дараах үе (Post Close session): | 6 |
| 12 дугаар зүйл. Захиалга оруулах (Entering orders)..... | 6 |
| 13 дүгээр зүйл. Захиалгын сангийн төрлүүд /Division of Market/..... | 6 |
| 14 дугаар зүйл. Арилжааны хэсгүүд (Trading Session) | 7 |
| 15 дугаар зүйл. Арилжааны шимтгэл тооцох. | 7 |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАХИАЛГЫН ТӨРӨЛ, НӨХЦӨЛ | 7 |
| 16 дугаар зүйл. Захиалгын төрлүүд (Types of Orders)..... | 7 |
| 17 дугаар зүйл. Нөхцөлт захиалга (Limit Orders)..... | 7 |
| 18 дугаар зүйл. Зах зээлийн захиалга (Market Orders)..... | 7 |
| 19 дугаар зүйл. Захиалгын онцлог шинжүүд (Order attributes) | 7 |
| 20 дугаар зүйл. Захиалгын баталгаажилт (Order validation)..... | 11 |
| 21 дугаар зүйл. Арилжигдах нэгж (Trading Unit)..... | 11 |
| 22 дүгээр зүйл. Захиалга биелүүлэх (Order Execution)..... | 11 |
| 23 дугаар зүйл. Ханшийн хяналт. | 12 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ӨМНӨХ ҮЕ | 14 |
| 24 дүгээр зүйл. Арилжааны өмнөх үе. (Pre-Trading) | 14 |
| ТАВДУГААР БҮЛЭГ. НЭЭЛТИЙН ДУУДЛАГА АРИЛЖААНД ЗАХИАЛГА ОРУУЛАХ | 15 |
| 25 дугаар зүйл. Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах. (Opening Auction Call)..... | 15 |
| 26 дугаар зүйл. Нээлтийн ханш тооцогдох алгоритм /Opening Algorithm/ | 16 |
| ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭНГИЙН АРИЛЖАА (REGULAR TRADING) | 19 |
| 27 дугаар зүйл. Хэлцэл хийгдэх дараалал (Method of transactions) | 19 |
| ДОЛООДУГААР БҮЛЭГ. БАГЦЫН АРИЛЖАА (BLOCK TRADES) | 21 |

| | | |
|---|--|-----------|
| 28 | дугаар зүйл. Багцын Арилжаа..... | 21 |
| 29 | дүгээр зүйл. Багцын арилжааны үед шивэгдэх захиалгын онцлог. (Type of transactions) | 21 |
| 30 | дугаар зүйл. Ханш тогтох үйл явц (Price determination mechanism) | 21 |
| 31 | дүгээр зүйл. Захиалгын нөхцөлийг өөрчлөх | 21 |
| 32 | дугаар зүйл. Захиалгын хүчинтэй байх хугацаа | 21 |
| 33 | дугаар зүйл. Ханшийн хязгаарлалт..... | 22 |
| 34 | дүгээр зүйл. Арилжигдах нэгж (Trading Unit) | 22 |
| 35 | дугаар зүйл. Захиалгын тухай мэдээлэл (Visibility) | 22 |
| 36 | дугаар зүйл. Статистик үзүүлэлтүүд | 22 |
| НАЙМДУГААР БҮЛЭГ. БҮГДИЙГ НЬ БИЕЛҮҮЛЭХ ЭСХҮЛ ҮЛ БИЕЛҮҮЛЭХ ДУУДЛАГА | | |
| АРИЛЖААНЫ ЗАХИАЛГЫН САН | | 23 |
| 37 | дугаар зүйл. Бүгдийг нь биелүүлэх эсвэл үл биелүүлэх /All or None, AON/ дуудлага худалдааны захиалгын сан (All or Non Auction Book)..... | 23 |
| 38 | дугаар зүйл. Арилжааны үе (Trading sessions)..... | 23 |
| 39 | дүгээр зүйл. Захиалгыг өөрчлөх (Amendments)..... | 24 |
| 40 | дүгээр зүйл. Ханшийн хяналт (Price Monitoring)..... | 24 |
| 41 | дүгээр зүйл. Захиалгын тухай мэдээлэл (Visibility)..... | 24 |
| 42 | дугаар зүйл. Статистик үзүүлэлтүүд | 24 |
| ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХИАЛГЫГ ӨӨРЧЛӨХ, ЦУЦЛАХ | | 25 |
| 43 | дугаар зүйл. Захиалгыг өөрчлөх/ цуцлах (Amendment/Cancellation of orders)..... | 25 |
| 44 | дүгээр зүйл. Захиалга цуцлах..... | 25 |
| 45 | дугаар зүйл. Захиалгыг өөрчлөх | 25 |
| 46 | дугаар зүйл. Захиалга өөрчлөх болон цуцалснаас үүсэх үр дагавар | 25 |
| 47 | дугаар зүйл. Хэлцлийг баталгаажуулах, цуцлах..... | 25 |
| АРАВДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ХААЛТЫН ҮЕ | | 27 |
| 48 | дугаар зүйл. Арилжааны хаалтын үе (Market Close). | 27 |
| 49 | дугаар зүйл. Хаалтын ханшийн тооцоолол (Closing Price calculation)..... | 27 |
| АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЛЭХ, ТҮГЭЭХ..... | | 28 |
| 50 | дүгээр зүйл. Зах зээлийн мэдээллийг нийтлэх, түгээх (Dissemination of Market Information)..... | 28 |
| АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ. ХААЛТЫН ДАРААХ ҮЕ | | 29 |
| 51 | дугаар зүйл. Хаалтын дараах үе (Post Close)..... | 29 |
| АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААГ ТҮР ЗОГСООХ..... | | 30 |
| 52 | дугаар зүйл. Арилжааг түр зогсоох (Trading Halts) | 30 |
| 53 | дугаар зүйл. Үнэт цаасны арилжааг түр зогсоох (Security Halts) | 30 |

| | |
|---|-----------|
| АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАДГАЛАМЖИЙН ПРОГРАММ ДАХ МЭДЭЭЛЛИЙГ ШИНЭЧЛЭХ..... | 31 |
| 54 дугаар зүйл. Хадгаламжийн програм дах мэдээллийг шинэчлэх (Depository Updates)..... | 31 |
| 55 дүгээр зүйл. Үнэт цаасны эзэмшлийн лавлагаа (Holding Query)..... | 31 |
| АРВАНТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД | 32 |
| 56 дүгээр зүйл. МХБ-ийн үүрэг..... | 32 |
| 57 дүгээр зүйл. Гэнэтийн үйл явдал..... | 32 |
| 58 дугаар зүйл. Журамд өөрчлөлт оруулах | 32 |
| Хавсралт 1..... | 33 |

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Журмын зорилт.

1.1. Энэхүү журмын зорилго нь Монголын Хөрөнгийн Бирж /цаашид МХБ гэх/-ийн үнэт цаасны арилжааны төрөл, хэлцэл хийгдэх нөхцөл, арилжааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Журмын нэр томъёоны тайлбар.

~~2.1. Энэхүү журамд өөрөөр заагаагүй бол түүнд тусгагдсан мэргэжлийн хэллэг, ойлголтыг Тайлбар тольд тусгагдсаны дагуу ойлгоно.~~

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор хассан./

2.1 Журамд хоёрдмол утга гарсан тохиолдолд МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ (Board of Directors), эсхүл түүнээс байгуулагдсан хороо (Committee), томилогдсон төлөөлөгч этгээд (designee) нь МХБ-ийн журмуудын утгыг тайлбарлах эрхтэй байна.

2.2. ТУЗ, хороо, эсхүл төлөөлөгч этгээдийн гаргасан тайлбар нь эцсийнх бөгөөд арилжааны гишүүний хувьд заавал мөрдөгдөх хэм хэмжээ байна.

2.3. Энэхүү журмын 2.2.-т заасан тайлбарыг арилжааны гишүүн нь эс зөвшөөрсөн тохиолдолд гомдлоо Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/-нд 7 хоногийн дотор гаргаж болно.

2.4. Энэхүү журам нь МХБ-ийн үйл ажиллагааны аливаа хэм хэмжээтэй зөрчилдөх тохиолдолд энэ журмыг мөрдөнө.

3 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ

3.1. Энэхүү журам нь Электрон арилжааны систем /цаашид ЭАС гэх/-ээр (The Electronic Trading System) арилжаалагддаг хувьцаа (shares), варрант (warrants), хаалттай сангийн нэгж (units of close-end funds), биржийн сангийн хувьцаа (ETF), “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-д заасан болон СЗХ-ноос үнэт цаас хэмээн тодорхойлсон бусад санхүүгийн хэрэгсэл /цаашид эдгээрийг “үнэт цаас” гэх/-ийн арилжаанд мөрдөгдөнө.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан. /

4 дугаар зүйл. Электрон арилжааны систем.

4.1. ЭАС гэж (The Electronic Trading System) МХБ-ийн арилжаанд оролцогчдын оруулсан үнэт цаас худалдах, худалдан авах захиалгын биелэлтийг хангах зориулалт бүхий цахим системийг ойлгоно.

4.2. Үнэт цаас худалдах, худалдан авах захиалга бүрийн ханш болон тоо хэмжээ зэрэг мэдээлэл нь “Захиалгын нэгдсэн сан”-д (a central electronic Order Book) бүртгэгдэнэ.

4.3. Арилжаа явагдах үед энэхүү журмын 4.2-т заасан захиалгыг тогтсон аргачлалын дагуу нийцүүлсний үндсэн дээр хэлцэл хийгдэх ханш тогтоно.

4.4. Гүйцэтгэгдсэн хэлцлийн үнийн дүн, тоо ширхэг зэрэг мэдээллийг цахим сүлжээ ашиглан хэлцэл хийсэн гишүүн бүрт тэр даруй мэдэгдэнэ.

5 дүгээр зүйл. МХБ-ийн арилжааны үе шат.

5.1. МХБ-ийн “Арилжааны Өдөр” нь дор дурьдсан үе шатуудаас бүрдэнэ.

- 5.1.1. Арилжааны өмнөх үе (Pre-Trading)
- 5.1.2. Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах (Opening Auction Call)
- 5.1.3. Энгийн арилжаа (Regular Trading)
- 5.1.4. Арилжааны хаалтын үе (Market Close)
- 5.1.5. Хаалтын дараах үе (Post Close)

6 дугаар зүйл. Арилжааны өмнөх үе (Pre-Trading).

6.1. Арилжаа хөтлөгч нь өмнөх арилжааны өдөр системд орсон энэхүү журмын 19.4.1, 19.4.3-т заасан захиалгыг өөрчилж, эсхүл цуцалж болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

6.2. Арилжааны өмнөх үед шинэ захиалга шивэх, хэлцэл хийгдэх боломжгүй.

7 дугаар зүйл. Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах (Opening Auction Call):

7.1. Нээлтийн дуудлага арилжааны эхэн үед арилжаанд оролцогчид нь шинэ захиалга оруулж болно.

7.2. Нээлтийн дуудлага арилжааны төгсгөлд систем нь Захиалгын санг (Order Book) түр хааж захиалгуудыг нээлтийн дуудлага арилжаагаар (Opening Auction) хооронд нь нийцүүлж эхэлнэ.

7.3. Нээлтийн дуудлага арилжаа нь нээлтийн ханшийг (Opening Price) тогтоох ба Нээлтийн дуудлага худалдааны дагуу биелэгдэх захиалгуудыг тодорхойлно.

8 дугаар зүйл. Энгийн арилжаа (Regular Trading)

8.1. Энэхүү журмын 27 дугаар зүйлд заасны дагуу Захиалгын санд байгаа захиалгуудыг шинээр орж буй захиалгуудтай нийцүүлэх ажиллагаа явагдана. Захиалга биелэгдэх боломжгүй бол захиалгын санд үлдэнэ.

9 дүгээр зүйл. Ханшийн хэт өөрчлөлт

9.1. Тодорхой нэг үнэт цаасны ханш хэт өндөр хувиар хэлбэлзэх нөхцөл бүрдсэн тохиолдолд /цаашид Ханшийн хэт өөрчлөлт үүссэн гэх/ тус үнэт цаасны хувьд арилжаа зогсоно.

9.2. Энэхүү зүйлийн 9.1-д заасан үнэт цаасыг систем нь “Нээлтийн дахин дуудлага арилжаанд захиалга оруулах” (Re-Opening Auction Call) болон “Нээлтийн дахин дуудлага арилжаа”-нд (Re-Opening Auction) шилжүүлнэ.

9.3. Энэхүү зүйлийн 9.2.-д заасан ажиллагаа нь “Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах” (Opening Auction Call) болон “Нээлтийн дуудлага арилжаа”-ны (Opening Auction) тухай энэхүү журмын Тавдугаар бүлэгт заасны дагуу зохицуулагдана.

10 дугаар зүйл. Арилжааны хаалтын үе (Market Close)

10.1. Арилжааны хаалтын үед үнэт цаас тус бүрийн хаалтын ханшийг тооцно.

10.2. Хаалтын ханшыг тооцсоны дараа тус ханшийг “Хаалтын ханш мэдээлэх үе”-ээр (Closing Price Publication session) мэдээлнэ.

Холбогдох нөхцөл нь бүрдсэн гэж үзвэл МХБ нь өөрийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр хаалтын ханшийг (Closing Price) тогтоох “Хаалтын дуудлага худалдаа”-г (Closing Auction) идэвхжүүлнэ.

11 дүгээр зүйл. Хаалтын дараах үе (Post Close session):

11.1. Хаалтын дараах үед Арилжаанд оролцогчид дараагийн арилжааны өдрийн (next trading day) “Нээлтийн дуудлага арилжаа”-нд (Opening Auction Call) оруулах захиалгаа шинэчлэн бэлдэж болно.

12 дугаар зүйл. Захиалга оруулах (Entering orders)

12.1. Арилжаанд оролцогчид “Арилжааны терминал”-аар дамжуулан электрон арилжааны системд захиалгаа шивж оруулна. Арилжаанд оролцогч нь захиалгаа оруулахдаа захиалгын үнэ ханш, тоо ширхэг, захиалгын төрөл, хүчинтэй байх хугацаа зэрэг захиалгын үзүүлэлтүүд нь алдаагүй, зах зээлийн дүрэм журамтай нийцсэн болохыг баталгаажуулна. /Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

12.2. Арилжааны терминал нь (the trading terminals) дор дурьдсан 3 функцийг гүйцэтгэнэ.

12.2.1. Арилжааны мэдээг харуулах (display of market data),

12.2.2. Арилжаанд оролцогчийн захиалгыг харуулах (display of trader’s order);

12.2.3. Хийгдсэн хэлцэл болон хүлээн авсан шинэ захиалгыг харуулах (display of executions and acceptance of new orders); захиалгыг өөрчлөх, цуцлах (amendments and cancellation of orders).

12.3. ЭАС нь захиалгыг хүлээн авсныг баталгаажуулж, захиалга орсон хугацааны тэмдэглэгээ хийхийн хамт захиалгын хүчин төгөлдөр эсэхийг шалгана.

12.4. ЭАС-ээс захиалгыг хүчин төгөлдөр гэж үзсэн тохиолдолд ажиллагааг үргэлжлүүлнэ. Харин захиалгыг хүчин төгөлдөр бус гэж үзсэн тохиолдолд зохих тайлбарын хамт захиалгыг буцаана.

12.5. Энэхүү журмын 20 дугаар зүйлд зааснаас бусад үзүүлэлтийг ЭАС баталгаажуулахгүй.

12.6. ЭАС нь арилжаалагдаж буй үнэт цаас бүрийн худалдах, худалдан авах талын захиалгын санг хөтөлнө.

13 дүгээр зүйл. Захиалгын сангийн төрлүүд /Division of Market/

13.1. Захиалгын сан нь “Энгийн захиалгын сан” (Regular Order Book) /цаашид “захиалгын сан” (Order Book) гэх/, “Багцын захиалгын сан” (Block Book) болон “Бүгдийг нь биелүүлэх эсвэл үл биелүүлэх” /All or None, цаашид AON дуудлага арилжаа гэх/ дуудлагын захиалгын сан гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

14 дугаар зүйл. Арилжааны хэсгүүд (Trading Session)

14.1. МХБ-ээс амралтын өдөр хэмээн тодорхойлсноос бусад Даваа-Баасан гаригуудад арилжаа явагдана. Арилжааг МХБ-ийн “Арилжаа зохион байгуулах заавар”-т заасан цагийн хуваарийн дагуу явуулна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

14.2. Арилжаа явуулах цагийн хуваарийг МХБ-ийн санал болгосноор СЗХ батална. ЭАС-д техникийн саатал гарсан тохиолдолд МХБ нь арилжааны цагийн хуваарьт зохих өөрчлөлтийг оруулж болно.

15 дугаар зүйл. Арилжааны шимтгэл тооцох.

15.1. МХБ нь арилжааны шимтгэлийг энэхүү журмын хавсралт 1-д дурьдсан аргачлалын дагуу тооцож авна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАХИАЛГЫН ТӨРӨЛ, НӨХЦӨЛ

16 дугаар зүйл. Захиалгын төрлүүд (Types of Orders)

16.1. ЭАС-д дор дурьдсан хоёр төрлийн захиалгыг оруулж болно.

16.1.1. Нөхцөлт захиалга (Limit Orders);

16.1.2. Зах зээлийн захиалга (Market Orders);

17 дугаар зүйл. Нөхцөлт захиалга (Limit Orders)

17.1 Нөхцөлт захиалга гэж худалдаж авах үнийн дээд түвшин, эсхүл худалдах үнийн доод түвшинг заасан захиалгыг ойлгоно.

18 дугаар зүйл. Зах зээлийн захиалга (Market Orders)

18.1. Зах зээлийн захиалга гэж тухайн үеийн зах зээлийн хамгийн сайн ханшаар (at the best price) үнэт цаасыг худалдах, эсхүл худалдан авах захиалгыг ойлгоно.

18.2. Зах зээлийн захиалга нь “Энгийн арилжааны үе”-д (Regular Trading) захиалгын санд хадгалагдахгүй. “Энгийн арилжааны үе”-д оруулсан зах зээлийн захиалга нь хэсэгчлэн биелсэн тохиолдолд, түүний биелэгдээгүй үлдсэн хэсэг нь 60 секундын дотор хүчингүй болно.

19 дугаар зүйл. Захиалгын онцлог шинжүүд (Order attributes)

19.1. Захиалга нь дор дурьдсан онцлог шинжтэй байна.

19.1.1. Захиалгын тодотгол (Order Qualifiers)

19.1.2. Түүний хүчинтэй байх хугацаа (Time in Force)

19.1.3. Нийт хэмжээ болон бусдад харагдах тоо ширхэг (Size and Disclosed quantity)

19.2. Арилжаанд оролцогч нь захиалгын биелэх нөхцөлийг тодорхойлохдоо энэхүү журмын 19.1-д заасан онцлог шинжүүдийг ашиглана.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

19.3. Захиалгын тодотгол (Order Qualifiers) нь хэмжээ, хүчинтэй байх хугацаа болон ханшийн хязгаарлалт зэргийг үндэслэн түүний биелэх нөхцөлийг нарийвчлан тогтоох зорилготой бөгөөд дор дурьдсан 6 хэлбэртэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

19.3.1. Тодотголгүй захиалга (No qualifiers)

Тодотголгүй захиалга нь хүчинтэй байх хугацааны хувьд зөвхөн тухайн ӨДӨР-ийн буюу Day захиалга байх үндсэн тохиргоотой системд бүртгэгдэнэ. Өөрөөр хэлбэл, энэхүү захиалгын биелэлт нь захиалгын санд оруулсан тухайн өдөртөө гүйцэтгэгдэх бөгөөд хэрэв биелээгүй тохиолдолд тэрхүү арилжааны өдрийн эцэст захиалгын сангаас устгагдах болно. Захиалга заасан ханшаар эсвэл илүү сайн ханшаар биелэгдэнэ. Хэрэв захиалга хэсэгчлэн биелэгдсэн бол түүний биелэгдээгүй үлдсэн хэсэг нь захиалгын санд үлдэх бөгөөд биелэгдэх, цуцлагдах, эсвэл хүчингүй болох хүртлээ хадгалагдана.

19.3.2. Бүхэлд нь даруй биелэгдэх эсвэл цуцлагдах захиалга /Fill or Kill, цаашид FOK захиалга гэх/

Энэ нь тухайн заасан тоо ширхэг бүхий үнэт цаасыг даруй худалдаж авах эсвэл худалдахыг хүссэн тодотгол бүхий захиалга юм. Хэрэв захиалгыг бүхэлд нь биелүүлэх боломжгүй бол бүрэн цуцлагдах (kill) болно. /захиалга нь захиалгын санд хадгалагдахгүй/. Систем нь FOK захиалгыг “Нээлтийн дуудлага арилжаа”-ны үеэр (Opening Auction Call) хүлээж авахгүй.

~~*/Хөлбөгдөх нөхцөл нь бүрдсэн гэж үзвэл МХБ нь өөрийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр энэхүү функцийг идэвхжүүлнэ./*~~

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор хассан./

19.3.3. Даруй биелүүлэх эсвэл цуцлах /Immediate or Cancel, цаашид ИОС захиалга гэх/

Уг захиалга нь захиалгыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн даруй биелүүлэхийг хүссэн тодотгол бүхий захиалга юм. Хэрэв захиалга даруй биелэгдээгүй тохиолдолд бүхэлдээ хүчингүй болно. Хэрэв захиалга даруй хэсэгчлэн биелэгдвэл, захиалгын үлдсэн хэсэг нь цуцлагдана. Систем нь ИОС захиалгыг “Нээлтийн дуудлага арилжаа”-ны үеэр (Opening Auction Call) хүлээж авахгүй.

19.3.4 Минимумаас их дүнгээр биелэгдэх MinFill захиалга

Уг захиалга нь худалдах, худалдан авах хамгийн бага тоо хэмжээг зааж өгөх бөгөөд заасан хэмжээнээс бага хэмжээгээр биелэгдэхгүй байх нөхцөлтэй захиалга юм. Систем нь MinFill захиалгыг “Нээлтийн дуудлага арилжаа”-ны үеэр (Opening Auction Call) хүлээж авахгүй.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор нэмсэн./

19.3.5 Нээлтийн дуудлага арилжааны OPG захиалга

Уг захиалга нь “Энгийн арилжаа”-ны үед ашиглагдахгүй, зөвхөн “Нээлтийн дуудлага арилжаа” (Opening Auction Call) –ны үед оруулах захиалга бөгөөд нээлтийн дуудлага арилжаа дуусахад түүний биелэгдээгүй үлдсэн хэсэг нь хүчингүй болох нөхцөлтэй захиалгын төрлийг хэлнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор нэмсэн./

19.3.6 Дуудлага арилжааны үеийн нууцалсан захиалга /Hidden order in Auction/

Арилжаанд оролцогч нь их хэмжээний захиалгыг тухайн үнэт цаасны ханшид ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр “Дуудлага арилжаа” (Auction)–ны үеэр түүнийг хэсэгчлэн хувааж, захиалга бүрийн зөвхөн зарим хэсгийг бусдад харагдахаар оруулж болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор нэмсэн./

19.4 Хүчинтэй байх хугацаа /Time in Force, цаашид TIF гэх/

TIF-ийн сонголтууд нь тухайн захиалгыг захиалгын санд хэдий хугацаанд хадгалагдахыг зааж өгөх үүрэгтэй.

19.4.1 Цуцлах хүртэл хүчинтэй /Good till Cancel, цаашид GTC захиалга гэх/

Захиалга цуцлагдах хүртлээ эсвэл хуанлийн 30 өдөр хүчинтэй байна.

19.4.2 Заасан цаг хүртэл хүчинтэй /Good till Time, цаашид GTT захиалга гэх/

Тухайн арилжааны өдрийн заасан цаг хүртэл хүчинтэй байна.

19.4.3 Заасан өдрийг хүртэл хүчинтэй /Good till Day, цаашид GTD захиалга гэх/

Хэлцэл хийгдээгүй тохиолдолд захиалга нь заасан арилжааны өдөр дуусахад хүчингүй болно. /хамгийн ихдээ хуанлийн 30 өдөр байна./

19.4.4 Өдрийн захиалга /Day order, цаашид DAY захиалга гэх/

Захиалгын санд оруулсан тухайн арилжааны өдрийн эцэст цуцлагдах захиалга.

19.5 Нийт хэмжээ болон бусдад харагдах тоо ширхэг (Size and Disclosed quantity)

Захиалгын хэмжээг захиалгын нийт хэмжээ гэж үзнэ. Арилжаанд оролцогч нь их хэмжээний захиалгыг тухайн үнэт цаасны ханшид ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр гүйцэтгэх зорилгоор түүнийг хэсэгчлэн хувааж, захиалга бүрийн зөвхөн зарим хэсгийг бусдад харагдахаар оруулж болно. Захиалгын харагдах хэмжээг ийнхүү зааж өгснөөр захиалга уг харагдах захиалгын хэмжээний багцаар биелнэ. Хэрэв харагдаж буй нэг багцын захиалга биелвэл, үлдэх хэсэг нь цаг хугацааны эрэмбээ (time priority) алдана. Холбогдох баримт бичигт (an apposite Notice) заасны дагуу, захиалгын харагдах хэмжээ нь нийт захиалгын хэмжээний тогтоосон хувиас илүү байх ёстой. Шинээр орж ирсэн захиалгын нийт хэмжээг захиалгын санд байгаа захиалгуудтай нийцүүлэхдээ уг захиалгын харагдах хэмжээг хайхрахгүй, учир нь хэлцэл хийхэд уг хэмжээ нь харагдахгүй байна. Захиалгын

санд оруулсан, тодорхой хэсэг нь харагдах захиалгыг дээр дурьдсан аргын дагуу харагдах хэмжээний багц багцаар биелүүлдэг.

~~/Холбогдох нөхцөл нь бүрдсэн гэж үзвэл МХБ нь оорийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр энэхүү функцийг идэвхжүүлнэ./~~

~~/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор хассан./~~

ГУРАВДУГААР БҮЛЭГ. АРИЛЖАА ЯВАГДАХ ШАТЛАЛ (TRADING PROCEDURE)

20 дугаар зүйл. Захиалгын баталгаажилт (Order validation)

20.1 Оруулсан захиалгын нөхцөлүүд нь зохистой байгаа эсэхийг ЭАС баталгаажуулна.

20.2 Шивэгдэж буй захиалга бүрийг дараах үзүүлэлтүүдээр

баталгаажуулна: 20.2.1 Захиалгын хэмжээ зохистой эсэх (valid size)

20.2.2 Үнэт цаасны код зөв эсэх (valid symbol)

20.2.3 Тухайн үнэт цаас арилжааг зөвшөөрсөн эсэх /бүртгэлээс хасагдаагүй (de-listed), арилжааг түр зогсоогоогүй байгаа (suspended) гэх мэт/

20.2.4 Урьдчилан тогтоосон үнийн хязгаар дотор (predefined Price Band) тухайн захиалгын ханш орж буй эсэх

20.2.5 Ханшийн өөрчлөлт зөвшөөрөгдөх эсэх (valid price change) /ханшийн өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэмжээг /tick size¹ /-г МХБ-ээс холбогдох баримт бичгээр тогтооно/

20.2.6 Харилцагчийн (client ID) болон арилжаанд оролцогчийн (trader ID) код таарч байгаа эсэх

20.2.7 Гадаадын хөрөнгө оруулагчийн эзэмшилд байж болох үнэт цаасны тоо ширхгийн хязгаар (Volume within foreign ownership limits)

20.2.8 Үнэт цаас худалдагч нь шаардлагатай хэмжээний үнэт цаас эзэмшдэг эсэх

20.3 Систем нь дээрх баталгаажилт хийгдсэн захиалгуудыг биелүүлэхээр хүлээн авна. Хүлээн авсан захиалгад арилжааны системээс захиалгын тусгайлсан код (order ID) өгөх ба захиалгатай холбоотой аливаа асуудалд уг кодыг ашиглана.

20.4 Захиалга нь энэхүү журмын 20.2-г заасан үзүүлэлтийн аль нэгээр баталгаажигдаагүй бол ЭАС-ээс захиалгыг буцаах бөгөөд баталгаажаагүй үзүүлэлтийг арилжааны явцад тодорхойлж мэдээллэнэ. ЭАС хүлээж аваагүй захиалгыг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

21 дугаар зүйл. Арилжигдах нэгж (Trading Unit)

21.1 Бүртгэлтэй үнэт цаас бүрийн арилжигдах хамгийн бага нэгж нь 1 ширхэг байна. МХБ нь тогтоосон хязгаараас бага зах зээлийн ханштай үнэт цаасны арилжигдах нэгжийн хэмжээг өөрөөр тогтоож болох бөгөөд энэ тухай мэдэгдэнэ.

22 дүгээр зүйл. Захиалга биелүүлэх (Order Execution)

22.1 “Арилжааны терминал” ашиглан шинээр шивэгдсэн захиалга нь ЭАС-д шилжинэ. Шивэгдсэн бүх захиалгууд нь ЭАС дээр гүйцэтгэгдэнэ.

22.2 ЭАС-ээр захиалгын төрлийг тогтоох боломжтой байх буюу одоогийн төрлийг тодорхойлох, анх захиалга орж ирсэн үеэс хийгдсэн гүйлгээний түүхийг харах боломжтой.

¹Tick Size- ханшийн өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хамгийн доод хэмжээ бөгөөд үнэт цаас бүрээр тохируулах боломжтой.

22.3 Захиалгууд үнэ болон цаг хугацааны дарааллаар эрэмбэлэгдэх ба захиалга биелэгдэхээс өмнө захиалгыг өөрчлөх, цуцлах боломжтой байна. Нээлтийн дуудлагын арилжааны үед оруулсан захиалгыг Нээлтийн алгоритмын (Opening Algorithm) дагуу, энгийн арилжааны үед оруулсан захиалгыг үнэ болон цаг хугацааны эрэмбийн дагуу нийцүүлнэ.

23 дугаар зүйл. Ханшийн хяналт.

23.1 Ханшийн хэт өөрчлөлт

23.1.1 Үнэт цаас нь дараахь хоёр төрлийн жишиг ханшаас тодорхой хувиар тогтоогдох ханшийн хязгаартай байна:

А. Статик баримтлах ханш (Static Reference Price): өмнөх өдрийн хаалтын ханш/ хамгийн сүүлийн дуудлага арилжааны ханш

Б. Динамик баримтлах ханш (Dynamic Reference Price): хамгийн сүүлд хийгдсэн хэлцлийн ханш (Last Traded Price)

23.1.2 Энэхүү зүйлийн 23.1.1-д заасан ханшуудын тогтоосон хязгаар давсан үнэ бүхий хэлцэл хийгдэх нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн үнэт цаасны арилжааг түр зогсооно. (Trading Halt).

23.1.3 Энэхүү зүйлийн 23.1.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд “Нээлтийн дахин дуудлага арилжаанд захиалга оруулах” үе (Re-Opening Auction Call) эхэлж, энэхүү журмын тавдугаар бүлэгт заасны дагуу “Нээлтийн дахин дуудлага арилжаа” (Re-Opening Auction) явагдана.

23.1.4 Арилжааг нь түр зогсоох нарийн заалт, түүний үргэлжлэх хугацааг МХБ тогтоож, холбогдох баримт бичгээрээ мэдэгдэнэ.

23.2 Ханшийн хязгаар.

23.2.1 МХБ нь арилжаанд оролцогчдын захиалгыг хамгаалах зорилгоор ханшийн хязгаар /Price Bands/-ыг тогтооно.

23.2.2 Аливаа нэг үнэт цаасны ханшийн хязгаарыг Статик баримтлах ханшийн (Static Reference Price) тодорхой хувиар тогтооно. Тухайн өдрийн арилжааны туршид хувьцааны ханш өсөх, буурах хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшаас 15 хувиас илүүгүй байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

23.2.3 ЭАС-д оруулж буй аливаа захиалгын ханш нь энэхүү журмын 23.2.2-т заасан ханшийн хязгаараас илүүгүй байна.

~~23.2.4 Ханшийн хязгаар нь жишиг ханшаас (Reference Price) дээш, доош ижил хувиар хэлбэлзэх ханшаар тодорхойлогдоно.~~

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор хассан./

23.2.4 Энэхүү зүйлд заасан ханшийн хязгаартай холбоотой тусгайлсан зохицуулалтыг МХБ-ээс тогтоож, мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ӨМНӨХ ҮЕ

24 дүгээр зүйл. Арилжааны өмнөх үе. (Pre-Trading)

24.1 Арилжааны өмнөх үе нь энгийн арилжааны өдрийн (normal trading day) захиалгын сангийн эхний үе шат юм. Энэ үе шатанд “Нээлтийн дуудлага арилжаа” (Opening Auction) эхлэхийн өмнөх шаардлагатай ажиллагааг /захиалга цуцлах зэрэг/ явуулах боломжтой.

24.2 Энэ үе шатанд өмнөх арилжааны өдөр захиалгын санд орсон GTC захиалга болон GTD захиалгууд харагдана. Арилжаанд оролцогчид болон арилжаа хөтлөгч арилжааны өмнөх үед шинэ захиалга шивэх боломжгүй. Өмнөх өдөр захиалгын санд байсан GTC эсвэл GTD захиалгуудыг арилжаанд оролцогч өөрчлөх, цуцлах боломжгүй, харин арилжаа хөтлөгч уг захиалгуудыг өөрчилж, цуцалж болно.

24.3 Энэ үед зах зээл нь ‘Арилжааны өмнөх үе’ буюу ‘PRE-TRADING’ гэсэн статустай байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. НЭЭЛТИЙН ДУУДЛАГА АРИЛЖААНД ЗАХИАЛГА ОРУУЛАХ

25 дугаар зүйл. Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах. (Opening Auction Call)

25.1 Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах үед, захиалгын сангийн өмнөх үеэс үлдсэн идэвхгүй захиалгууд нь (passive orders) захиалгын санд хадгалагдан үлдэнэ. Энэ үед нөхцөлт (limit order) болон зах зээлийн захиалгуудыг (market order) шинээр оруулах, өөрчлөх, цуцлах боломжтой. Бүх шинэ захиалгууд нь захиалгын санд орж, дуудлага арилжаагаар биелэхэд бэлэн байна. ИОС, FOK нөхцөлтэй зах зээлийн (market order) болон нөхцөлт захиалгыг (limit order) хүлээж авахгүй.

25.2 Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах үе дуусахад систем нь захиалгын санг түр хааж, Нээлтийн дуудлага арилжаа (Opening Auction)-гаар захиалгуудыг нийцүүлж эхэлнэ. “Нээлтийн дуудлага арилжаа” нь (Opening Auction) захиалга нийцүүлэх алгоритмаар (matching algorithm) нээлтийн ханшийг тооцоолно. Тухайн үнэт цаасаар бүх хэлцэл нэг ханшаар буюу нээлтийн ханшаар (Opening Price) хийгдэнэ.

25.3 Нээлтийн дуудлага арилжааны үед систем нь хамгийн олон хэлцэл биелэх ханшаар нээлтийн ханшийг тодорхойлно. Нээлтийн дуудлага арилжааг амжилттай явуулахын тулд худалдан авах, худалдах тоо хэмжээ тэнцүү байх шаардлагагүй. Худалдан авах, худалдах захиалгын үнийн зөрүүнээс хамааран нөхцөлт захиалга (limit order) нээлтийн ханшаар (Opening Price) хэсэгчлэн биелэх эсвэл биелэгдэхгүй үлдэх магадлалтай. Хэрэв үнэт цаасны нээлтийн ханш нь нээлтийн дуудлагын арилжаагаар тогтоогүй бол дуудлага арилжааны дараах үеийн эхний арилжааны ханш нь түүний нээлтийн ханш (Opening Price) болно.

25.4 Шивэгдсэн захиалгуудыг нийцүүлснээр гарч ирэх магадлалтай хамгийн сүүлийн ханш нь (The last indicative uncrossing price – цаашид LIUPrice гэх) статик баримтлах ханш (Static Reference Price) МХБ-ээс тогтоосон хэлбэлзлийн дээд хэмжээнээс бага байх бол тус ханшийг зохистой гэж үзэх буюу хэлцэл хийгдэх дуудлага арилжааны ханш (auction price) гэж тооцно.

25.5 Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах үед (Opening Auction Call), МХБ нь дуудлага арилжааны ханш /Indicative Auction Price - IAP/-ийг холбогдох баримт бичигт заасан давтамжаар арилжаанд оролцогчдод мэдээлнэ.

25.6 LIUPrice болон статик баримтлах ханш хоорондын зөрүү нь энэхүү журмын 25.4.-т заасан ханшийн хэлбэлзлийн дээд хэмжээнээс хэтэрвэл, нээлтийн дуудлага арилжаа (Opening Auction) нь МХБ-ээс холбогдох бичиг баримтаар тогтоосон хугацаагаар дахин сунгагдана. Мөн нээлтийн дуудлага арилжаа нь (Opening Auction) зах зээлийн захиалгын тэнцвэргүй (market order imbalance) байдлаас хамааран сунгагдаж болно. /өөрөөр хэлбэл, зах зээлийн захиалгыг оролцуулан, дуудлага арилжааны ханшаар нийцүүлж болохгүй байгаа захиалгууд/.

25.7 Энэхүү журмын 25.4-т заасан хэлцэл хийгдэх үйл явц нь дуудлага арилжаанаас гарсан ханштай тэнцүү эсвэл түүнээс өндөр үнэтэй худалдан авах захиалгыг тус дуудлага арилжаанаас гарсан ханштай тэнцүү эсвэл түүнээс бага ханш бүхий худалдах захиалгатай тухайн захиалга бүрийн ханш болон цаг хугацааны эрэмбийн дагуу хооронд нь нийцүүлэх бөгөөд энэ нь боломжит тоо хэмжээ дуусгавар болох хүртэл үргэлжилнэ. Зах зээлийн захиалга нь ямагт нөхцөлт захиалгын өмнө эрэмбэлэгдэнэ.

25.8 Нээлтийн болон ханшийн хэлбэлзлээс үүдэлтэй явагдсан дуудлага худалдааны эцэст хэсэгчлэн эсвэл бүхлээрээ биелэгдээгүй нөхцөлт захиалга нь дараагийн арилжааны захиалгын санд шилжихдээ үнийн болон цаг хугацааны анхны эрэмбээ алдахгүй². Биелэгдээгүй зах зээлийн захиалга нь тухайн дуудлага арилжааны төгсгөлд даруй цуцлагдах болно.

25.9 Нээлтийн дуудлага арилжааны үед, зах зээл ‘Дуудлага арилжаа’ буюу ‘AUCTION’ гэсэн статустай байна.

26 дугаар зүйл. Нээлтийн ханш тооцогдох алгоритм /Opening Algorithm/

26.1 Дуудлага арилжааны үр дүнд гарах нээлтийн ханш нь дараах шатлалын дагуу тооцогдоно:

26.1.1 Захиалгуудын хамгийн их хэлцэл биелэгдэх боломжтой ханшийг тодорхойлно. (maximizes the executable volume)

26.1.2 Хамгийн их хэлцэл биелэх нэгээс дээш үнэ тодорхойлогдвол, захиалгууд биелсний дараа үлдэх үлдэгдэл хамгийн бага байх ханшийг сонгоно.

26.1.3 Хэрэв хамгийн их хэлцэл биелэх болон үлдэгдэл хамгийн бага байх нэгээс дээш ханш тодорхойлогдвол захиалгын сан дах тэнцвэрийн нөлөөг тусгана.

26.1.4 Захиалгын сан тэнцвэртэй байвал, тухайн үнэт цаасны динамик баримтлах ханшид илүү ойр байх ханш байна.

26.1.5 Хэрэв динамик баримтлах ханш байхгүй бол хамгийн дээд ханшийг сонгоно.

² GTC эсвэл GTD захиалга нь хэсэгчлэн биелсэн эсвэл огт биелэгдээгүй бол уг захиалга ханш болон цаг хугацааны анхны эрэмбээрээ дараа өдрийн нээлтийн дуудлага худалдаанд шилжинэ.

АРИЛЖААНЫ ЖУРАМ

Нээлтийн дуудлага худалдааны жишээ

1. Захиалгын сан.

ЭАС-д үнэт цаасны эрэлт нийлүүлэлтийг Захиалгын сангийн хэлбэрээр харуулдаг.

Захиалгын сан нь тодорхой нэг үнэт цаасны тухайн цаг хугацаан дахь бүх худалдах, худалдан авах захиалгын эрэмбэлэгдсэн нийлбэр байна.

Доорхи хүснэгтийн ханш гэсэн баганад, боломжит ханшийг ихээс нь бага руу жагсаасан байна.

Хүснэгт 1

| Худалдан авах захиалга (Buy Orders) | | | Ханш | Худалдах захиалга (Sell Orders) | | |
|-------------------------------------|--|--|-------|--|---|----------------|
| Захиалгууд (А) | Нийлбэр (Cumulative) | | | Нийлбэр (Cumulative) | | Захиалгууд (В) |
| | Тухайн үнээр нийт хэдэн үнэт цаас худалдан авах захиалга ирсэн (Per Price) | Хамгийн өндөр үнээс (from highest price) | | Хамгийн бага үнээс (from lowest price) | Тухайн үнээр нийт хэдэн үнэт цаас худалдах захиалга ирсэн (Per Price) | |
| 200+400 | 600 | 600 | 1,010 | | | |
| 300 | 300 | 900 | 1,005 | | | |
| 400 | 400 | 1,300 | 1,000 | | | |
| 500 | 500 | 1,800 | 995 | 3,800 | 700 | 700 |
| 800+100 | 900 | 2,700 | 990 | 3,100 | 600 | 200+300+100 |
| 1,000 | 1,000 | 3,700 | 985 | 2,500 | 600 | 100+200+300 |
| | | | 980 | 1,900 | 300 | 300 |
| | | | 975 | 1,600 | 300 | 100+200 |
| | | | 970 | 1,300 | 1,300 | 100+500+700 |

“Ханш” гэсэн баганын зэргэлдээх хоёр баганад буй мэдээллийг үндэслэн систем нь нээлтийн ханш тооцож эхэлнэ. Тус хоёр баганад ханшийн хамгийн багаас нь эхлэн хоёр талд буй захиалгуудыг дээш эрэмбэлсэн байна. Үнэт цаасны худалдан авах талд хамгийн өндөр үнээсээ эрэмбэлэгдэн захиалгууд нэмэгдэнэ.

Харин худалдах талд, худалдах хамгийн бага үнээс эхлэн хамгийн өндөр үнэ хүртлээ эрэмбэлэгдэн орно. Багана /А/, /Б/-ийн захиалгууд нь тухайн ханшаар захиалга оруулсан дарааллаараа /зүүнээс баруун тийш/ харагдаж байна.

2. Нээлтийн алгоритм

Нээлтийн үед хэлцэл хийх ерөнхий дараалал нь энэхүү журмын 26 дугаар зүйлийн дагуу явагдана. Нээлтийн алгоритм Хүснэгт 1-г үзүүлсэн жишээний хувьд дараах байдалтай байна:

Хамгийн их хэмжээний захиалга биелүүлэх боломжит ханш нь 990 байна /2,700 хувьцаа/ [1-р алхам]

Худалдан авах тал нь бага хэмжээтэй буюу 2,700 ширхэг хувьцаа байхад эсрэг талд 3,100 ширхэг хувьцаа худалдах захиалга байна [2-р алхам]

Худалдах талд буй 2,500 ширхэг хувьцаа нээлтийн ханшаас сайн ханштай байгаа учраас захиалгыг биелүүлж, үлдсэн $2,700 - 2,500 = 200$ хувьцааны захиалга захиалгын сангийн эрэмбийн дагуу нээлтийн ханшаар биелэгдэхээр үлдэнэ. [3-р алхам]

ЭАС-д хамгийн түрүүнд оруулсан худалдах захиалга нь /200-г худалдах/ худалдан авах захиалгын илүүдэл хэсэгтэй нийцэж биелнэ [4-р алхам]

Зах зээл нь энгийн арилжаанд шилжихэд биелэгдээгүй үлдсэн захиалгууд нь захиалгын санд хадгалагдан үлдэнэ. [5-р алхам]

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭНГИЙН АРИЛЖАА (REGULAR TRADING)

27 дугаар зүйл. Хэлцэл хийгдэх дараалал (Method of transactions)

27.1 Энгийн арилжааны үед хэлцэл хийгдэх дараалал нь дор дурьдсан эрэмбээр явагдана.

27.1.1 Ханшийн эрэмбэ (Price priority). Хамгийн өндөр ханшаар худалдан авах, хамгийн бага ханшаар худалдах захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна. Захиалгын санд шивэгдсэн нийт захиалгууд нь ханшийн дарааллаар эрэмбэлэгдэнэ.

27.1.2 Цаг хугацааны эрэмбэ (Time priority). Худалдан авах болон худалдах захиалгууд нь ханшийн ижил түвшинд биелэгдэх нөхцөл бүрдсэн бол цаг хугацааны хувьд эхэнд шивэгдсэн захиалгууд нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна. Энгийн арилжааны үед ханш тогтоох, захиалгуудыг нийцүүлэх аргачлалыг дор дурьдав.

Энгийн Арилжааны жишээ

Шинээр шивэгдсэн захиалгыг нийцүүлэх хэд хэдэн шатлал бүхий ажиллагааны жишээг дор харуулав.

| Хүснэгт 2 | | |
|--|------|------------------------------------|
| ABC үнэт цаас | | |
| Баримтлах ханш /хамгийн сүүлд хийгдсэн хэлцлийн ханш/:990. | | |
| Тухайн ханшаар худалдан авах тоо ширхэг | Ханш | Тухайн ханшаар худалдах тоо ширхэг |
| | 995 | 200+300 |
| | 990 | 400 |
| 200 | 985 | |
| 500 | 980 | |

ABC үнэт цааснаас 700 ширхэг тус бүрийг нь 995 төгрөгөөр худалдан авах шинэ захиалга шивэгдсэн гэж үзье. 400 хувьцааг ₮900-р худалдах захиалгаас эхлэн захиалгыг нийцүүлэх ажиллагаа явагдана. Эхний журмын дагуу худалдах нөхцөлт захиалга ханшийг тогтооно.

Анхны хэлцэл: 400 хувьцааг ширхгийг нь ₮990-өөр хийгдэнэ.

Худалдан авах захиалгаас 300 ширхэг хувьцаа үлдэнэ. Тэдгээрийг дараагийн захиалга болох 200 хувьцааг ширхгийг нь ₮995-өөр худалдах захиалгатай нийцүүлнэ. ₮995-өөр 2 захиалга байгаа тул захиалга оруулсан хугацааны дарааллыг харна. 200 хувьцааны захиалга нь өмнө нь орсон байна. Эхний дүрмийг дахин ашиглана.

Хоёр дахь хэлцэл: 200 хувьцаа ₮995-өөр хийгдэнэ.

АРИЛЖААНЫ ЖУРАМ

Үлдсэн захиалгыг 300 хувьцааг ширхгийг нь ₮995-өөр худалдах захиалгатай нийцүүлнэ. Эхний дүрмийг дахин ашиглана.

3 дахь хэлцэл: 100 хувьцаа ₮995.

Үүний дараагаар шинээр орж ирсэн худалдан авах захиалга нь /700 хувьцааг ₮995-өөр/ биелэгдэнэ. Захиалгын сан нь дараах байдалтай харагдана:

| Хүснэгт 3 | | |
|---|------|------------------------------------|
| Үнэт цаас ABC | | |
| Харьцуулалтын ханш: 995 | | |
| Тухайн ханшаар худалдан авах тоо хэмжээ | Ханш | Тухайн ханшаар худалдах тоо хэмжээ |
| | 995 | 200 |
| 200 | 990 | |
| 500 | 985 | |

ДОЛООДУГААР БҮЛЭГ. БАГЦЫН АРИЛЖАА (BLOCK TRADES)

28 дугаар зүйл. Багцын Арилжаа

28.1 Багцын Арилжаа (МХБ-ийн захиалгын сангаас гадуурх арилжаа) гэж МХБ-ээс гадуур хэлэлцэн тохирсон, арилжааны системд мэдээлэгдэж буй арилжааг хэлнэ.

28.2 Үнэт цаасны томоохон багцын арилжааг үнэт цаасны ханшийн хэт хэлбэлзэл үүсгэхгүй гүйцэтгэх зорилгоор МХБ нь багцын тусгайлсан арилжааг явуулна. Багцын Арилжаа хийх захиалгуудыг Энгийн Захиалгын Сангаас тусдаа Захиалгын Санд (Багцын Захиалгын Сан) бүртгэн авч, арилжаална.

28.3 Багцын арилжаа нь МХБ-ээс гадуур, урьдаас хэлэлцэн тохирсон арилжаа учраас хэлцэлд оролцогч эсрэг талын арилжааны гишүүний тусгай кодыг (contra firm ID) шинээр захиалга шивэхдээ давхар оруулна.

29 дүгээр зүйл. Багцын арилжааны үед шивэгдэх захиалгын онцлог. (Type of transactions)

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

29.1 Багцын арилжааны үед шивэгдэх захиалга нь дор дурьдсан онцлог шинжтэй байна.

29.1.1 Хэлцлийн талууд нь харилцан тусгай таних дугаараа зааж өгөх хүртэл Багцын арилжаа хийгдэхгүй.

29.1.2 Багцын арилжааны хэлцлийн талууд тус бүр нь тухайн хэлцэл хийх үнэт цаас, түүний ханш, тоо ширхэг, арилжааны тусгай дугаар, хэлцлийн талуудыг харилцан зааж өгнө.

29.1.3 Багцын захиалгын сан (Block Book) дахь худалдах, худалдан авах хоёр талын шивсэн захиалгуудын тусгай код, ханш, тоо ширхэг, арилжааны тусгай дугаар болон хэлцэлд оролцогч эсрэг талын код зэрэг мэдээлэл нь хоорондоо тохирч байх тохиолдолд хэлцэл хийгдэнэ.

29.1.4 Хэрэв худалдагч тал нь өөрийн дансанд хэлцэл хийхэд шаардагдах тооны үнэт цаасгүй тохиолдолд тухайн багцын арилжаа даруй цуцлагдана.

29.1.5 Багцын арилжааны захиалгын санд зөвхөн нөхцөлт захиалга шивэгдэж орно. Зах зээлийн захиалга даруй цуцлагдана.

30 дугаар зүйл. Ханш тогтох үйл явц (Price determination mechanism)

30.1 Багцын арилжаа нь тухайн захиалгад тусгагдсан ханшаар хийгдэнэ.

31 дүгээр зүйл. Захиалгын нөхцөлийг өөрчлөх

31.1 Багцын захиалгын санд орсон захиалгын нөхцөлийг өөрчлөх, тус захиалгыг цуцлах боломжтой байна.

32 дугаар зүйл. Захиалгын хүчинтэй байх хугацаа

32.1 Багцын арилжааны биелэгдээгүй захиалга нь дараах нөхцөлд хүчингүй болно:

32.1.1 Хэрэв захиалга нь Day захиалга бол тухайн арилжааны өдрийн эцэст хүчингүй болно;

32.1.2 Хэрэв захиалга нь GTT захиалга бол шивэгдсэн тухайн арилжааны өдрийн товлосон цагт хүчингүй болно;

32.1.3 Хэрэв захиалга нь GTD нөхцөлтэй бөгөөд түүний хүчингүй болох өдөр нь тус арилжааны өдөртэй давхацсан бол тухайн арилжааны өдрийн эцэст мөн хүчингүй болно.

33 дугаар зүйл. Ханшийн хязгаарлалт

33.1. Багцын арилжааны ханш буурах хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшаас 15 хувиас илүүгүй байх, өсөх хэлбэлзэл нь ханшийн хязгааргүй байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

34 дүгээр зүйл. Арилжигдах нэгж (Trading Unit)

34.1. Зөвхөн МХБ-ийн холбогдох баримт бичигт тусгагдсан тоо ширхгийн доод хэмжээнд хүрсэн багцын захиалгыг хооронд нь нийцүүлнэ.

35 дугаар зүйл. Захиалгын тухай мэдээлэл (Visibility)

35.1 Багцын захиалгын санд орсон захиалгууд нь энгийн захиалгын санд харагдахгүй, тиймээс бусад арилжаанд ханшийн нөлөө үзүүлэхгүй. Зөвхөн хийгдсэн хэлцлийн тухай мэдээлэл гарна.

36 дугаар зүйл. Статистик үзүүлэлтүүд

36.1 Багцын арилжаа нь тухайн үнэт цаасны тоо хэмжээ, эргэлт зэрэг зах зээлийн үзүүлэлтүүдэд нөлөөлөх боловч албан ёсны хаалтын ханш болон индекс тооцоход ашиглагдахгүй.

**НАЙМДУГААР БҮЛЭГ. БҮГДИЙГ НЬ БИЕЛҮҮЛЭХ ЭСХҮЛ ҮЛ
БИЕЛҮҮЛЭХ ДУУДЛАГА АРИЛЖААНЫ ЗАХИАЛГЫН САН**

**37 дугаар зүйл. Бүгдийг нь биелүүлэх эсвэл үл биелүүлэх /All or None, AON/
дуудлага худалдааны захиалгын сан (All or Non Auction Book)**

37.1 Үнэт цаасны томоохон багцын захиалгыг арилжааны системд бүгдийг нь биелүүлэх эсвэл огт биелүүлэхгүй байх нөхцлөөр худалдан авах эсвэл худалдах ажиллагааг явуулахад AON захиалгын санг ашиглана. Үнэт цаасны дуудлага худалдаа зарласан тухай МХБ-ийн мэдэгдлийн дагуу дуудлага худалдааны санал зарлагдаж, энэхүү санал нь тогтоосон өдрийн туршид нээлттэй байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

37.2 AON захиалгын сан нь энгийн захиалгын сангаас тусдаа байна. AON захиалгын санд дуудлага худалдааны худалдах, худалдан авах аль тал болох, ханшийн дээд доод хязгаар болон тоо ширхгийг тодорхойлж захиалгыг оруулна. Оролцогчид эхний захиалгын эсрэг талд захиалгаа тогтсон өдрийн туршид оруулан дуудлага худалдааг эхлүүлсэн талаас үнэт цаас худалдан авах, эсвэл худалдахаар өрсөлдөнө.

37.3 Нэгэнт AON дуудлага эхэлсэн бол, өөр дуудлага худалдааг /өмнөх дуудлага худалдаа эхлүүлсэн талын эсрэг тал болон тоо ширхгийн хувьд өөр байх дуудлага худалдаа/ өмнөх дуудлага худалдаа дуусах эсвэл түүнийг зогсоох хүртэл дахин зарлагдахгүй.

37.4 AON дуудлага нь ханшийн аль ч түвшинд биелэж болно. Хэлцлийн ханшид аливаа хязгаарлалт байхгүй /өөрөөр хэлбэл, өмнөх өдрийн хаалтын ханш, хамгийн сүүлд арилжигдсан ханш зэргээс ихээр хэлбэлзэж болно/.

37.5 AON дуудлагын үед зөвхөн нөхцөлт GTC захиалгыг хүлээж авна.

38 дугаар зүйл. Арилжааны үе (Trading sessions)

38.1 AON захиалгын сан нь 2 үеэс бүрдэнэ:

38.1.1 Захиалга оруулах (Order Entry)

Захиалга оруулах хэсэг нь AON захиалгын сангийн үндсэн хэсэг юм. Уг шатанд захиалгуудыг захиалгын санд оруулна.

38.1.2 AON дуудлага арилжаа (AON Auction)

AON дуудлага арилжаа нь дараах байдлаар явагдана.

а. AON захиалгын сангийн бүх захиалгууд нь худалдах, худалдан авах аль тал болох, үнэ ханш, тоо ширхгийн мэдээллийг агуулсан байна.

б. AON захиалгын санд хоёроос илүү идэвхтэй захиалга байж болохгүй. /өөрөөр хэлбэл, худалдах, худалдан авах тал тус бүр нэгээс илүүгүй захиалга байна/

в. Багцыг худалдан авах эсвэл худалдах хүсэлтэй байгаа дансаар захиалгыг байршуулна. Эхний захиалга нь дуудлагыг эхлүүлнэ. Тус захиалга нь дуудаж буй тал, хэмжээ, ханшийн дээд доод хязгаарыг тодорхойлно.

г. Эхний захиалгыг оруулсны дараа оролцогчид тогтоосон өдрүүдэд /өөрөөр хэлбэл, AON дуудлага арилжаа явагдах өдрүүдийн туршид/ үнэт цаасанд үнэ хаялцсаны эцэст дуудлага арилжаа явагдана.

д. Эхний захиалгын дараа шивэгдэх бүх захиалгууд нь эхний захиалгын эсрэг талд байх ёстой.

е. Эхний захиалгын эсрэг талд байгаа захиалгыг илүү сайн ханш хэлсэн тухайн эсрэг талд орсон захиалгаар өөрчилж болно.

ё. Хэрэв илүү сайн ханштай захиалга эсрэг талд ирвэл, уг талын өмнөх захиалгыг систем устгана.

ж. Эхний захиалга нь дуудлагыг эхлүүлсэн захиалга тул илүү сайн ханштай захиалгаар солигдох боломжгүй байна.

з. AON дуудлага арилжаа нь AON-ийн үргэлжлэх хугацаа дуусах өдөр хийгдэнэ. Жишээлбэл, дуудлагын үргэлжлэх хугацаа нь 3 хоног гэвэл, эхний захиалга орж ирснээс хойш /эхний захиалга оруулсан өдөр нь үргэлжлэх хугацаанд орно/ арилжааны 2 өдрийн /хуанлийн өдөр биш/ дараа дуудлага арилжаа хийгдэнэ.

i. Хэрэв захиалгын санд худалдах, худалдан авах хоёр талын захиалга байвал дуудлага арилжаа нь “Захиалга оруулах” үеийн төгсгөлд хийгдэнэ.

ii. Хэлцлийн ханш нь эхний захиалгын эсрэг талын захиалгын хязгаарт ханш байна.

iii. Хэрэв тухайн үед захиалгын санд зөвхөн эхний захиалга байвал эхний захиалгыг цуцална.

39 дүгээр зүйл. Захиалгыг өөрчлөх (Amendments)

39.1 Захиалгыг зөвхөн арилжаа хөтлөгч цуцалж болно. Харин арилжаа хөтлөгч болон арилжаанд оролцогчийн аль аль нь захиалгыг өөрчлөхгүй.

40 дүгээр зүйл. Ханшийн хяналт (Price Monitoring)

40.1 Энэхүү журмын 23 дугаар зүйлд заасан ханшийн хяналт нь AON-н захиалгын санд хамаарахгүй. AON-н захиалгын сан дахь захиалгууд болон хэлцлүүдийн ханш нь ханшийн хязгаар (price band) тогтооход ашиглагдах баримтлах ханш (Reference Price) болохгүй. Энгийн захиалгын санд (Regular Trading Book) ашиглагдах ханшийн хязгаар болон баримтлах ханш нь AON-н захиалгын санд хамаарахгүй.

41 дүгээр зүйл. Захиалгын тухай мэдээлэл (Visibility)

41.1 Худалдах, худалдан авах хамгийн сайн үнийн саналыг агуулсан (best bid and offer) AON-н захиалгын санал нь бүх оролцогчдод харагдана. Биелсэн хэлцлийг мэдээлнэ.

42 дугаар зүйл. Статистик үзүүлэлтүүд

42.1 AON-н захиалгын санд биелсэн хэлцлүүд нь үнэт цаасны арилжааны эргэлт, тоо хэмжээ гэх мэт зах зээлийн мэдээлэлд нөлөөлөх боловч албан ёсны хаалтын ханш болон индекс зэрэгт тооцогдохгүй.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХИАЛГЫГ ӨӨРЧЛӨХ, ЦУЦЛАХ

43 дугаар зүйл. Захиалгыг өөрчлөх/ цуцлах (Amendment/Cancellation of orders)

43.1 ЭАС-д захиалгыг оруулсны дараа тухайн захиалгыг цуцлах, эсхүл өөрчлөх боломжтой тохиолдолд арилжаанд оролцогч нь захиалгыг өөрчлөх, эсхүл цуцалж болно. Захиалга өөрчлөгдөж болох хэдий ч арилжаанд оролцогч биелэхээс нь өмнө цуцлах, өөрчлөх зорилгоор ЭАС-д захиалга оруулахыг хориглоно.

44 дүгээр зүйл. Захиалга цуцлах

44.1 Арилжаанд оролцогч нь захиалга биелэгдэхээс өмнө хэдийд ч захиалгаа цуцалж болно. Хэрэв захиалга хэсэгчлэн биелэгдсэн бол биелэгдээгүй үлдсэн хэсгийг нь цуцалж болно. AON-н дуудлага арилжааны захиалгын санд орсон захиалгыг цуцлах боломжгүй.

45 дугаар зүйл. Захиалгыг өөрчлөх

45.1 Захиалгын санд буй захиалгын ханш, хэмжээ, хэлцэлд оролцогч эсрэг талын болон арилжааны код /зөвхөн багцын арилжаанд хамаарна/ (Contra Firm and Trade ID /for Block Trades only), хүчинтэй байх хугацаа (Validity date) зэрэг нөхцлүүдийг захиалга биелэгдэхээс нь өмнө эсвэл захиалгын биелэгдээгүй үлдсэн хэсэгт өөрчлөн засварлаж болно. Захиалгыг өөрчилснөөр түүний цаг хугацааны эрэмбэ шинэчлэгдэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

46 дугаар зүйл. Захиалга өөрчлөх болон цуцалснаас үүсэх үр дагавар

46.1 Захиалгыг өөрчилсөн, эсхүл цуцалснаас үүсэх үр дагаврыг МХБ хариуцахгүй.

46.2 Арилжаанд оролцогчийн буруутай ажиллагааны улмаас захиалга өөрчлөгдсөн, эсхүл цуцлагдсан тохиолдолд МХБ-ээс түүнд сануулах болон бусад хэлбэрээр хариуцлага хүлээлгэж болно.

47 дугаар зүйл. Хэлцлийг баталгаажуулах, цуцлах

47.1 ЭАС-ээр хийгдсэн хэлцлийг баталгаажсан хэлцэл гэж үзнэ.

47.2 Арилжаанд оролцогч алдаатай хэлцэл хийсэн нь зах зээлийн нийтлэг эрх ашигт сөргөөр нөлөөлөх, системийн эрсдэл үүсгэхээр байгаа онцгой тохиолдолд, арилжааны гишүүн нь хэлцлийг цуцлуулах тухай хүсэлтийг МХБ-д гаргаж болно.

47.3 Арилжааны гишүүн нь 47.2-т заасан хүсэлтийг тухайн хэлцэл хийгдсэнээс хойш 30 минутын дотор үндэслэл бүхий тайлбарын хамт МХБ-ийн Хяналтын албанд бичгээр /цахимаар/ ирүүлнэ.

47.4 МХБ нь арилжааны гишүүнээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн, хэлцэлд оролцогч эсрэг талыг төлөөлж буй арилжааны гишүүнтэй нууцлалыг хангах зарчмаар холбогдож, хэлцэл цуцлахыг зөвшөөрөх эсэхийг лавлана.

47.5 Хэлцэлд оролцогч эсрэг талыг төлөөлж буй арилжааны гишүүн нь хэлцэл цуцлах зөвшөөрлийг МХБ-д олгохоос өмнө өөрийн харилцагчтай зөвшилцөж түүний зөвшөөрлийг авсан байна.

47.6 МХБ нь дараах нөхцөлүүд зэрэг хангагдсан тохиолдолд алдаатай хэлцлийг цуцлах эсэхийг шийдвэрлэх ба МХБ-ийн шийдвэр нь эцсийнх байна.

47.6.1 Хэлцлийн эсрэг хэлцэл хийх боломжгүй нь тодорхой болсон

47.6.2 Хэлцэл нь энгийн арилжааны тоо ширхэг, үнэ ханшаас огцом савалгаатай буюу хэлцэл алдаатай болох нь илэрхий байх

47.6.3 Хэлцлийг цуцлуулах тухай хүсэлт нь үндэслэл бүхий бөгөөд 47.3-т заасан хугацаанд ирүүлсэн байх

47.6.4 Хэлцэлд оролцогч эсрэг тал нь хэлцэл цуцлахыг зөвшөөрч байгаагаа МХБ-д бичгээр /цахимаар/ мэдэгдсэн байх

47.7 МХБ нь хэлцлийг цуцлахаар шийдвэрлэсэн тохиолдолд тухайн арилжааны өдрийн 13.50 цагаас өмнө хэлцлийг цуцалж баталгаажсан хэлцлийн жагсаалтаас хасна.

47.8 МХБ нь хэлцэл цуцалсан даруй ЭАС-ээр дамжуулан зах зээлийн оролцогчдод мэдээлнэ.

47.9 Цуцалсан хэлцэл нь тухайн үнэт цаасны хаалтын ханш, индекс зэрэгт нөлөөлсөн бол холбогдох засварыг 14.00 цагаас өмнө оруулж мэдээлнэ.

47.10 МХБ нь цуцалсан хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг хэлцлийг цуцлуулсан арилжааны гишүүнээр төлүүлнэ. Энэ торгууль нь 500 мянган төгрөгөөс багагүй байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор нэмсэн./

АРАВДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ХААЛТЫН ҮЕ

48 дугаар зүйл. Арилжааны хаалтын үе (Market Close).

48.1 Арилжааны хаалтын үед зах зээл “Хаалттай” (‘CLOSE’) гэсэн статустай байна.

49 дугаар зүйл. Хаалтын ханшийн тооцоолол (Closing Price calculation)

49.1 Хаалтын ханшийг тухайн үнэт цаасны **сүүлийн нэг цагийн арилжааны** Тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханшаар /Volume weighted average price буюу VWAP/ тооцоолно. Хэрэв тухайн үнэт цаас сүүлийн нэг цагт арилжигдаагүй бол хаалтын ханшийг тухайн арилжааны өдөр хийгдсэн бүх арилжааны тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханшаар тооцоолно. Арилжаа хаагдсанаас хойш дараагийн ажлын өдрийн “Нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах” (Opening Auction Call) үе эхлэх хүртэл ямар ч ажиллагаа явагдахгүй. Зах зээл дээрх нөхцөл байдал өөрчлөгдвөл тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханшийг тооцоолоход ашиглах хугацааг МХБ өөрчилж болно. Өөрчлөлтийн талаар МХБ-ээс тусгай мэдэгдлээр (the Notice) мэдээлнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЛЭХ, ТҮГЭЭХ

50 дүгээр зүйл. Зах зээлийн мэдээллийг нийтлэх, түгээх (Dissemination of Market Information)

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

50.1 ЭАС нь зах зээлийн оролцогч болон хөрөнгө оруулагчдад зах зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авах боломжоор хангана.

50.2 Үнэт цаас тус бүрээр хийгдсэн хэлцлийнх нь ханш болон тоо ширхгийн талаарх мэдээллийг МХБ-ийн цахим хуудсаар бодит цагийн горимоор мэдээлнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

50.3 Захиалгын бүрэн сан (the full Order Book) болон гүйлгээний түүх нь (the transaction history) зөвхөн арилжаанд оролцогчийн терминалаас (Traders' terminal) харагдана. Зах зээл хаагдах үеийн төгсгөлд, “Хаалтын ханш мэдээлэх” (Closing Price Publication) үеэр хаалтын ханшийг (Closing Price) мэдээлнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ. ХААЛТЫН ДАРААХ ҮЕ

51 дугаар зүйл. Хаалтын дараах үе (Post Close)

51.1 Хаалтын дараах үед ямар ч хэлцэл хийгдэхгүй.

51.2 Уг хэсэгт захиалгын зохицуулалттай холбоотой дор дурьдсан ажиллагаа хийгдэнэ.

51.2.1 Арилжаанд оролцогч болон арилжаа хөтлөгчийн аль нь ч шинээр захиалга оруулах боломжгүй.

51.2.2 Арилжаанд оролцогч өмнө нь оруулсан захиалгаа өөрчилж болохгүй, харин арилжаа хөтлөгч өөрчлөх боломжтой захиалгын ханш, тоо ширхэг, захиалгын хүчинтэй байх хугацаа зэрэг нөхцөлийг засварлаж болно.

51.2.3 Өмнө нь оруулсан захиалгыг арилжаанд оролцогч болон арилжаа хөтлөгчийн аль аль нь цуцалж болно.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ. АРИЛЖААГ ТҮР ЗОГСООХ

52 дугаар зүйл. Арилжааг түр зогсоох (Trading Halts)

52.1 Техникийн саатал болон бусад давагдашгүй хүчин зүйлсийн улмаас арилжааны хэвийн явц алдагдсан тохиолдолд Энгийн арилжааны (Regular Trading hours) дундуур МХБ-ийн зүгээс зах зээлийг түр зогсоож (Market Halts) болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

52.2 Зах зээлийг зогсоосон үед, оруулсан захиалгуудыг цуцалж болох боловч захиалгыг өөрчлөх, эсвэл шинээр захиалга оруулах боломжгүй байна.

52.3 Зах зээлийг түр зогсоосон үед “ЗОГССОН” (‘HALT’) гэсэн статустай байна.

52.4 Үүний дараагаар МХБ нь:

52.4.1 Зах зээлийг үргэлжлүүлнэ: Дахин нээлтийн дуудлага зарлагдаж (Re-Opening Auction Call), дахин нээх дуудлага худалдаа (Re-Opening Auction) явагдсаны дараа, зах зээлийг зогсоохоос өмнөх статусдаа (Venue state) эргэж орно.

52.4.2 Зах зээлийг хаана /ЗОГСООГООД ХААХ/ (‘HALT AND CLOSE’).

53 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааг түр зогсоох (Security Halts)

53.1 МХБ нь энэхүү журмын 23.1.2-д заасны дагуу арилжааг түр зогсооно. МХБ зохистой ямар ч шалтгааны улмаас тодорхой нэг үнэт цаасны арилжааг түр зогсоож болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

53.2 Компаниас хийсэн мэдэгдэл/тодруулга нь зах зээлд хүрсэн даруйд үнэт цаасны арилжааг хэвийн явуулж эхэлнэ.

53.3 Арилжааг тухайн арилжааны өдөрт тодорхой хугацаагаар эсвэл МХБ-ээр олон нийтэд мэдээлүүлэхээр компаниас албан ёсны мэдэгдэл хүргүүлэх хүртэл нэг өдрөөс илүү хугацаагаар зогсоож болно.

53.4 МХБ нь үнэт цаас бүрт Circuit Breaker-ийн функцийг идэвхижүүлнэ.

Хэрэв үнэт цаасны ханш тодорхой хувиас хэтэрсэн бол /МХБ-ээс холбогдох баримт бичгээр тогтоосны дагуу/ уг үнэт цаасны арилжааг автоматаар зогсооно.

**АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАДГАЛАМЖИЙН ПРОГРАММ
ДАХ
МЭДЭЭЛЛИЙГ ШИНЭЧЛЭХ**

54 дугаар зүйл. Хадгаламжийн програм дах мэдээллийг шинэчлэх (Depository Updates)

54.1 Хэлцэл хийгдэх бүрт, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв /ҮЦГХТ/ дэх мэдээлэл онлайнаар шинэчлэгдэнэ. Худалдах захиалга орж ирэхэд харилцагчийн үнэт цаасны эзэмшлийг ҮЦГХТ-өөс лавлана.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

54.2 Харилцагч нь Чөлөөт үлдэгдэл (Free Balance) болон Худалдан авч буй үлдэгдэлдээ (Pending Buy Balance) хангалттай хэмжээний үнэт цаастай байгаа бол, уг харилцагч эзэмшдэг хэмжээнээсээ илүү захиалга өгөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс харилцагчийн дансны үлдэгдлээс худалдах хэмжээтэй нь дүйцэхүйц хэмжээний үнэт цаасыг хасна.

54.3 Худалдах захиалгуудад тусгагдсан тухайн үнэт цаасны тоо ширхгийг (open sell orders) сүүдрийн балансад /shadow balance/ оруулна. Тиймээс сүүдрийн баланс нь худалдахаар захиалга өгсөн үнэт цаасны тоо ширхгийг (pending sell orders) харуулна. Хэлцэл биелэгдэхэд харилцагчийн дансны үлдэгдэл болон сүүдрийн баланс нь хэлцлээр бий болсон өөрчлөлтийг тусгаж шинэчлэгдэнэ.

55 дүгээр зүйл. Үнэт цаасны эзэмшлийн лавлагаа (Holding Query)

55.1 Арилжааны гишүүд нь өөрсдийн арилжааны терминалаас харилцагчдын үнэт цаасны эзэмшлийн лавлагааг авах боломжоор хангагдана.

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД

56 дүгээр зүйл. МХБ-ийн үүрэг

56.1 ЭАС-ийн аливаа техникийн саатлаас үүссэн эсвэл МХБ-ийн ажилтан, төлөөлөгчид ЭАС-ийн ажиллагааг сайн дурын үндсэн дээр хянах явцад аливаа этгээдэд учирсан хохирлыг, МХБ болон арилжааны гишүүдийн харилцааг зохицуулах “Үйлчилгээ үзүүлэх гэрээ” болон “Гишүүнчлэлийн гэрээ”-нд заасан хэм хэмжээнээс өөрөөр хариуцах үүргийг МХБ хүлээхгүй.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

57 дүгээр зүйл. Гэнэтийн үйл явдал

57.1 Журмуудад тусгагдаагүй арилжаатай холбоотой Гэнэтийн үйл явдал (Contingency Event) үүссэн тохиолдолд СЗХ-той зөвшилцсөний үндсэн дээр түүнийг МХБ шийдвэрлэх эрхтэй. Уг шийдвэр нь эцсийнх байх ба бүх талууд дагаж мөрдөнө.

58 дугаар зүйл. Журамд өөрчлөлт оруулах

58.1 СЗХ-той зөвшилцсөний дагуу МХБ нь уг журмын заалтуудыг өөрчилж болно. Өөрчлөлтүүд нь даруй хүчин төгөлдөр болох буюу хүчин төгөлдөр болох хугацааг МХБ-ээс тогтооно. Өөрчлөлтийн тухай мэдээллийг арилжааны гишүүдэд бичгээр мэдэгдэнэ.

Хавсралт 1.

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

1. МХБ нь харилцагчийн тухайн өдрийн үнэт цаасны арилжаагаар хийсэн худалдах худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс хамааруулан шимтгэлийг дараах байдлаар тооцно. Үүнд:

1.1 Хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх худалдсан ба худалдан авсан тал тус бүрээс:

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

1.1.1. 100 сая хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.4 хувийн,

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

1.1.2. 100 саяас 1 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.38 хувийн,

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

1.1.3. 1 тэрбумаас 10 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.3 хувийн,

1.1.4. 10 тэрбумаас 30 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.2 хувийн,

1.1.5. 30 тэрбумаас дээш төгрөгийн үнийн дүнгээс 0.15 хувийн,

1.2. Энэхүү хавсралтын 1.1. дэх заалт нь хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжааны шимтгэл тооцоход нэгэн адил хамаарна

~~1.3. Хувьцааны багцын арилжаа хийгдсэн тохиолдолд худалдсан ба худалдан авсан тал тус бүр нь журмын хавсралтын 1.1-т зааснаас гадна тогтмол хэмжээний “Багцын арилжаа зохион байгуулах үйлчилгээний хөлө” төлнө. Тус үйлчилгээний хөлөийн хэмжээг Биржийн ТУЗ-өөс тогтооно.~~

~~*/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./*~~

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/08 тоот тогтоолоор хассан./

2. Анхдагч зах зээл дээр худалдагдсан Засгийн газар, орон нутгийн бондын арилжааны үнийн дүнгээс худалдсан талаас 0.12 хувь, худалдан авсан талаас 0.00875 хувийн,
3. Хоёрдогч зах зээл дээр Засгийн газар, орон нутгийн бонд худалдагч нь шимтгэлгүй үйлчлүүлэх ба харин худалдан авсан талаас 0.00875 хувийн,
4. Анхдагч зах зээл дээр компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдсан талаас 0.1575 хувь, худалдан авсан талаас 0.0175 хувийн,

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

5. Хоёрдогч зах зээл дээр компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдагч тал шимтгэлгүй, худалдан авагч талаас 0.0175 хувийн шимтгэлийг тус тус тооцон авна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./

6. Тодорхой этгээдтэй байгуулсан гэрээнд зааснаар шимтгэл, үйлчилгээний хөлсийг тооцон авч болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан./